

ЗЭЭЛИЙН ДУГААР ____ - ____

МОНГОЛ УЛС,

ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

хоорондын

(Эрчим хүч-3 төсөл)-ийн

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Сэлтийн явц
...
Тайлбар /Signature/ ...
... 11 сарын 19 өдөр

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү зээлийн хэлэлцээрийг, МОНГОЛ УЛС (цаашид "Зээлдэгч" гэх) болон ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК (цаашид "Банк" гэх)-ны хооронд доор гарын үсэг зурсан өдөр байгуулав. Зээлдэгч болон Банк хооронд дараах зүйлийг тохиролцов:

ЗҮЙЛ I — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЬЁО

- 1.01. Ерөнхий нөхцөл нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсон) уг Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг мөн.
- 1.02. Агуулга нь өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томьёо нь Ерөнхий нөхцөл, эсвэл Зээлийн хэлэлцээрт тодорхойлсон утгаар ойлгоно (үүнд Хэлэлцээрийн оршил хэсэг, хавсралтууд багтана).

ЗҮЙЛ II — ЗЭЭЛ

- 2.01. Банк нь Зээлдэгчид төслийг санхүүжүүлэх зорилгоор дөчин долоон сая (47,000,000) ам.долларын зээл (цаашид "Зээл" гэх) олгохыг зөвшөөрөв. Энэ үнийн дүнг Валют хөрвүүлэгчээр тухайн цагт нь хөрвүүлж болно.
- 2.02. Зээлдэгч нь энэ Хэлэлцээрийн Хуваарь 2-ын Хэсэг III-т заасны дагуу Зээлийн хөрөнгийг татан авч болно.
- 2.03. Үйлчилгээний хураамж нь зээлийн дүнгийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна.
- 2.04. Зээлийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг жилд нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна.
- 2.05. Хүүгийн түвшин нь Лавлах суурь хүү дээр Хувьсах хүүг нэмсэнтэй тэнцүү буюу Ерөнхий нөхцөлийн 3.02 (е) хэсэгт заасны дагуу хөрвүүлсэн хувь хэмжээ байна.
- 2.06. Төлбөр гүйцэтгэх өдөр нь жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдөр болон 09 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасны дагуу хийнэ.

ЗҮЙЛ III — ТӨСӨЛ

- 3.01. Зээлдэгч нь Төслийн зорилт болон ОУШ Хөтөлбөрийн хангах үүрэг хүлээж байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Үүнтэй холбогдуулан, Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн Зүйл V-ын заалтууд болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-т заасны дагуу Төслийг Эрчим хүчний яам "ЭХЯ"-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

ЗҮЙЛ IV — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 4.01. Хүчин төгөлдөр болоход дараах Нэмэлт нөхцөлийг хэрэгжүүлнэ:
 - a) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагааны гарын авлагыг Банкны хүлээн зөвшөөрсөн хэлбэр, агуулгаар баталсан байна; мөн
 - b) Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Банкны шаардлагад нийцсэн чиг үүрэг, бүрэлдэхүүн, нөөц, ажлын удирдамжтайгаар байгуулсан байна.
- 4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зуун наян (180) хоног байна.

24 оны 11 сарын 19 өдөр

- 4.03. Ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлийн 9.05 (b) хэсгийн хувьд, Зээлдэгчийн энэхүү Хэлэлцээрээр хүлээсэн үүрэг (төлбөрийн үүргээс бусад) дуусгавар болох огноо нь Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш хорин (20) жил байна.

ЗҮЙЛ V— ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ; ХАЯГ

- 5.01. Зээлдэгчийг төлөөлөгч нь санхүүгийн асуудал эрхэлсэн Сайд байна.

- 5.02. Ерөнхий нөхцөлийн 10 дугаар зүйлийн 10.01-д заасан зорилгоор,

- а) Зээлдэгчийн хаяг нь:

Сангийн яам
Засгийн газрын II байр,
С.Данзангийн гудамж 5/1 Д,
Улаанбаатар 15160,
Монгол Улс;

- б) Зээлдэгчийн цахим хаяг нь:

Факс:

976-11-320247


- 5.03. Ерөнхий нөхцөлийн 10 дугаар зүйлийн 10.01-д заасан зорилгоор:

- а) Банкны хаяг нь:

Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт хөгжлийн банк
1818 Н гудамж, N.W.
Вашингтон ДС 20433,
Америкийн Нэгдсэн Улс;

- б) Банкны цахим хаяг нь:

Телекс:	Факс:
248423(MCI) эсвэл	1-202-477-6391
64145(MCI)	



Гарын үсэг зурсан өдрөөр ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛС

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____


ОЛОН УЛСЫН СЭРГЭЭН БОСГОЛТ,
ХӨГЖЛИЙН БАНК

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____



ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилт нь төсөл хэрэгжүүлэх тухай газарт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбох цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүний найдвартай байдлыг сайжруулахад оршино.


Төсөл нь ОУШ Хөтөлбөрийн нэг үе шат бөгөөд дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Цахилгаан дамжуулах шугамын бүтээн байгуулалтын ажил, холбогдох дэд станцын өргөтгөл

Багануурын болон Чойрын дэд станц хооронд 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах шугамын бүтээн байгуулалтын ажил, холбогдох дэд станцын өргөтгөнө.

Бүрэлдэхүүн хэсэг 2. Чадавх бэхжүүлэх, төсөл хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх

Доорх техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх. Үүнд : (а) ЭХЯ болон холбогдох агентлаг, институтийн техникийн чадавх бэхжүүлэх, тэр дундаа худалдан авах ажиллагаа болон байгаль, орчин нийгмийн бодлогын чиглэлээр; (b) санхүүгийн удирдлага, худалдан авалт, байгаль орчин нийгмийн эрсдэл, нөлөөллийн менежмент, хяналт, тайлагнал, үнэлгээ зэрэг төслийн удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.



ХУВААРЬ 2

Төслийг хэрэгжүүлэх

Хэсэг I. Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт

A. Институтийн зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Төслийн үйл ажиллагааны гарын авлагад тусгасны дагуу төслийг хэрэгжүүлэх хугацаанд улс, орон нутгийн түвшинд Банкны шаардлагад нийцсэн бүтэц бүрэлдэхүүн, чиг үүрэг, орон тоо, нөөц бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулж ажиллуулна.
2. Зээлдэгч нь дээр дурдсанаар хязгаарлагдахгүйгээр дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
 - а) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг (1) сарын дотор ЭХЯ, төсөлд хамрагдахаар орон нутгийн захиргаа болон СЯ-ны төлөөллөөс бүрдсэн, ЭХЯ-аар ахлуулсан Төслийн удирдах хороог байгуулах бөгөөд Төслийн удирдах хороо нь Төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүрэг хүлээнэ.
 - б) ЭХЯ-ны дэргэд байгуулагдах Төсөл хэрэгжүүлэх нэгж нь (i) Жилийн ажлын төлөвлөгөө, улирлын тайлан бэлтгэх; (ii) худалдан авах ажиллагаа, санхүүгийн менежмент, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент болон гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх; (iii) Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ зэргийг багтаасан төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцаж ажиллах үүрэг хүлээнэ.

B. Төслийн үйл ажиллагааны гарын авлага


Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагааны гарын авлага (ТҮАГА)-д тусгасан зохицуулалт, журмын дагуу төслийг хэрэгжүүлэх (ТҮАГА болон энэ Хэлэлцээрийн заалтууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө) бөгөөд Банк урьдчилан бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд ТҮАГА-ын аливаа зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, татгалзах, зайлсхийх үйлдэл гаргаж үл болно.

C. Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв

1. Зээлдэгч нь ЭХЯ-аар дамжуулан Төслийг хэрэгжүүлэх хугацаанд (эсвэл Банкны сүүлд зөвшөөрсөн хугацаанд) дараагийн санхүүгийн жилд төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгож буй төслийн бүх үйл ажиллагаа, зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, энэ Хуваарийн Хэсэг E-д заасан байгаль орчин, нийгмийн хариуцлагын чиглэлээр авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг багтааж нэгтгэсэн жилийн ажлын төлөвлөгөө болон төсөв (ЖАТТ)-ийг бэлтгэж, жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор зөвшөөрөл авахаар Банканд хүргүүлнэ.
2. Зээлдэгч нь Төслийг Банкнаас хүлээн зөвшөөрсөн тухайн жилийн ажлын төлөвлөгөө болон төсөвт заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ ЖАТТ болон энэ Хэлэлцээрийн заалтууд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Хэлэлцээрийн заалтуудыг дагаж мөрдөнө.
3. Зээлдэгч нь Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ЖАТТ-т ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй, бусад этгээд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй.

D. Зээлдэгч талын санхүүжилт

Зээлдэгч нь ерөнхий нөхцөлийн 5.03 (Санхүүжилт болон бусад эх үүсвэрээр хангах) хэсгийн ерөнхий байдлыг хязгаарлахгүйгээр Төсөл хэрэгжих бүх хугацаанд:



- (1) хамгийн доод хэмжээ нь 840,000 ам.доллартой тэнцэх, эсвэл Банктай бичгээр тохиролцсон дүнгээр зохих хэмжээний эх үүсвэрийг ("Зээлдэгч талын санхүүжилт")-ийн 2(b) хэсэгт заасны дагуу цаг тухайд нь олгох буюу өөрийн хөрөнгөөр санхүүжилтийг хангах;
- (2) Банканд дээрх 1-р хэсгийн дагуу оруулах шаардлагатай Зээлдэгч талын санхүүжилтийн талаарх баримт бичгийн тайланг жилд хамгийн багадаа нэг удаа хүргүүлнэ; мөн
- (3) Зээлдэгч талын санхүүжилтээр санхүүжүүлж буй Төслийн бүх үйл ажиллагаа нь энэхүү Гэрээний шаардлагыг хангаж буй эсэх тэр дундаа Төслийн үйл ажиллагааны гарын авлагын заалтуудын дагуу хэрэгжиж байгаа эсэхийг баталгаажуулах.

Е. Байгаль орчин, нийгмийн стандартууд

1. Зээлдэгч нь төслийг байгаль орчин, нийгмийн стандартад нийцсэн, Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
2. Зээлдэгч нь дээрх 1 дэх зүйлд зааснаар хязгаарлагдахгүйгээр, төслийг Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (БОНХТ)-ний дагуу Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хэрэгжүүлнэ. Үүний тулд, Зээлдэгч нь дараах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:
 - a) БОНХТ-нд тусгагдсан арга хэмжээ, үйл ажиллагаанд БОНХТ-ний дагуу магадлан шалгалт хийж, үр дүнтэй хэрэгжүүлэх;
 - b) БОНХТ-г хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын санхүүжилт хангалттай байх;
 - c) БОНХТ-нд тусгасан бодлого, дүрэм, журмыг сахин мөрдөж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хангалттай тооны мэргэшсэн, туршлагатай ажилтантай байх; мөн
 - d) БОНХТ-нд заасны дагуу Банктай өөрөөр бичгээр тохиролцсоноос бусад тохиолдолд БОНХТ, эсвэл түүний аливаа заалтыг өөрчлөх, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, татгалзахгүй байх, БОНХТ-г шинэчлэгдмэгц энэ талаар олон нийтэд зохих ёсоор мэдээлэх.
3. БОНХТ болон энэхүү Хэлэлцээрийн заалт хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Хэлэлцээрийн заалтыг баримтална.
4. Зээлдэгч нь дараах шаардлагыг хангасан байна:
 - a) Тогтмол гаргах тайланг БОНХТ-нд заасан давтамжтайгаар цуглуулах, нэгтгэн бэлтгэж Банканд хүргүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авах, Банкнаас БОНХТ болон түүний байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгслүүд бодит нөхцөл байдалтай нийцэж байгаа эсэх талаар мэдээлэл хүссэн тохиолдолд, энэ тухай мэдээллийг даруй цуглуулж, нэгтгэн Банканд хүргүүлэх ба бүх тайланг хэлбэр, агуулгын хувьд Банк хүлээн зөвшөөрөхүйц байдлаар бэлтгэнэ. Тухайлбал, (i) БОНХТ-ний хэрэгжилтийн төлөв байдал; (ii) Хэрэв үүссэн бол, БОНХТ-г хэрэгжүүлэхэд саад учруулсан, эсвэл саад учруулахаар заналхийлсэн, нөхцөл байдал; (iii) ийм нөхцөл байдлыг засаж залруулах талаар авсан, эсвэл авах шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх тусдаа тайланг бэлтгэнэ; мөн
 - b) Төсөлтэй холбоотой, эсвэл төсөлд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй аливаа онцгой тохиолдол, осол, БОНХТ, түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн арга хэрэгсэл, Байгаль орчин, нийгмийн стандартаар байгаль орчинд үзүүлсэн мэдэгдэхүйц сөрөг нөлөөлөл, нөлөөлөлд өртсөн олон нийт, эсвэл ажилтнуудын талаар Банканд нэн даруй мэдэгдэнэ.
5. Зээлдэгч нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Гомдол барагдуулах хүртээмжтэй механизмыг бий болгож, сурталчилж, ажиллуулах ба аливаа санал гомдлыг Банканд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар

... үсэг /Signature/ ... *12*

2024 оны 11 сарын 19 өдөр

шийдвэрлэх, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд зүй зохистой бүхий л арга хэмжээг авна.

6. Зээлдэгч нь тендерийн сонгон шалгаруулалтын бүх бичиг баримт, төслийн хүрээнд хийгдэх барилгын ажлын гэрээнд гүйцэтгэгчид, туслан гүйцэтгэгчид болон хяналт тавих байгууллагуудын (а) БОНХТ-ний холбогдох заалтууд, түүнд дурдсан байгаль орчин, нийгмийн хариуцлагыг биелүүлж ажиллах; (б) дээрх гэрээний дагуу захиалсан, эсвэл гүйцэтгэсэн барилгын ажилд хамаарах байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, бэлгийн дарамт, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлийг арилгах талаар нарийвчлан авч үзсэн ёс зүйн дүрмийг баталж, бүх ажилтнууддаа өгч гарын үсэг зуруулж мөрдүүлэх үүргийн талаар тусгана.

Хэсэг II. Төслийн Хяналт-шинжилгээ, Тайлагнал ба Үнэлгээ

A. Төслийн тайлан

Зээлдэгч нь төслийн улирлын тайланг тухайн улирал дууссанаас нэг сарын дотор багтаан Банканд хүргүүлнэ.

B. Дунд хугацааны үнэлгээ

Зээлдэгч нь: (а) Төсөл хүчин төгөлдөр болсноос хойш хорин дөрвөн (24) сарын дараа, тайлант хугацаанд Төслийг хэрэгжүүлэх явцад гарсан ахиц дэвшлийг Банкны үндэслэл бүхий хүсэлтийн дагуу аль болох нарийвчлан тусгаж баримтжуулсан, энэхүү А хэсгийн дагуу гүйцэтгэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг харгалзан үзсэн, мөн Төслийг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх, Төслийн зорилгыг ханган биелүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлон тусгасан дунд хугацааны тайланг бэлтгэж Банканд хүргүүлнэ; (б) Дунд хугацааны тайланг хүргүүлснээс хойш дөчин тав (45) хоногт багтаан тайланг Банктай хамт хянаж үзэх ба дунд хугацааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж, энэ талаарх Банкны үнэлэлтэд үндэслэн Төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх, зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Хэсэг III. Зээлийн хөрөнгийг татан авалт

A. Ерөнхий зүйл.

Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн II зүйлийн заалтуудаар хязгаарлахгүйгээр, Зарцуулалт ба Санхүүгийн мэдээллийн захидлын дагуу Зээлийн хөрөнгийн зохих зардлыг санхүүжүүлэхэд хуваарилсан хэмжээгээр, хэрэв боломжтой бол дараах хүснэгтийн Ангилал тус бүрд заасан хувь хүртэлх хэмжээгээр төлөх зорилгоор Зээлийн хөрөнгийг татан авч болно.


Ангилал	Хуваарилагдсан зээлийн хэмжээ (ам. доллароор)	Санхүүжүүлэх зардлын хувь (татвар ноогдуулсан)
(1) Бараа, ажил, зөвлөхийн бус болон зөвлөхийн үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, төслийн сургалт	47,000,000	ОУСБХБ-ны 100%, ЖАТТ тус бүрээр
НИЙТ ДҮН	47,000,000	

B. Санхүүжилт татан авах нөхцөл, хугацаа.

1. Дээрх А хэсгийн заалтыг үл харгалзан, 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хийсэн Ангилал (1)-д хамаарах зөвшөөрөгдөх зардалд зориулж татан авсан нийт дүнгээр есөн сая таван зуун жаран найман мянган доллар (9,568,000 ам. доллар)-оос хэтрэхгүй хэмжээний төлбөр, бусад Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн төлбөр.

24 11 19

2. Хаагдах хугацаа 2029 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байна.




ХУВААРЬ 3

Хүлээсэн үүрэгтэй холбоотой элэгдлийн эргэн төлөлтийн хуваарь

Дараах хүснэгтэд Зээлийн үндсэн төлбөрийг эргэн төлөх хугацаа болон үндсэн төлбөр төлөх хугацаа тус бүрд ногдох зээлийн үндсэн дүнгийн нийт төлбөрийн хувийг ("Төлбөрийн хувь") харуулав.

Үндсэн төлбөрийн эргэн төлөлт

Үндсэн төлбөр төлөх хугацаа	Хэсэгчилсэн төлбөрийн хувь
2030 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.03000
2030 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.06000
2031 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.08000
2031 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.11000
2032 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.14000
2032 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.17000
2033 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.19000
2033 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.22000
2034 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.26000
2034 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.29000
2035 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.32000
2035 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.35000
2036 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.39000
2036 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.42000
2037 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.46000
2037 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.49000
2038 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.53000
2038 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.57000
2039 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.61000
2039 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.65000
2040 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.69000
2040 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.73000
2041 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.77000
2041 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.82000
2042 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.86000
2042 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	1.91000
2043 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	1.96000
2043 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.01000
2044 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.06000
2044 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.11000
2045 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.16000
2045 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.22000
2046 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.27000
2046 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.33000
2047 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.39000
2047 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.45000
2048 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.51000
2048 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.57000
2049 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.63000
2049 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.70000
2050 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.77000
2050 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.84000
2051 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	2.91000
2051 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.98000
2052 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	3.05000
2052 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	3.13000
2053 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	3.21000
2053 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	3.29000
2054 оны 03 дугаар сарын 15-ны өдөр	3.37000
2054 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр	2.96000



Тодорхойлолт

1. “Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв” буюу “ЖАТТ” гэсэн товчлол нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I-р хэсэгт дурдсан төлөвлөгөө, төсвийг хэлэх бөгөөд тухайн төлөвлөгөөнд Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.
2. “Авлигатай тэмцэх удирдамж” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 6 дахь хэсэгт заасан зорилгын үүднээс, 2006 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталж, 2011 оны 01 дүгээр сард шинэчилсэн, 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх “ОУСБХБ-ны зээл болон ОУХА-ийн зээл, буцалтгүй тусламжаар санхүүжүүлж буй төслүүдэд залилан мэхлэлт, авлигын асуудал гарахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх удирдамж”-ийг хэлнэ.
3. “Багануур дэд станц” гэж Зээлдэгчийн Улаанбаатар хотын Багануур дүүрэгт орших мөн нэртэй дэд станц болно.
4. “Чойр дэд станц” гэж Зээлдэгчийн Дундговь аймгийн Чойрт орших мөн нэртэй дэд станц болно.
5. “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө” буюу “БОНХТ” гэж 2024 оны 09 дүгээр сарын Төслийн Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөөг хэлэх бөгөөд үүнд энэхүү Хэлэлцээрт заасны дагуу Төслийн үзүүлэх байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллийг арилгахад чиглэсэн арга хэмжээ, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалт, хүн хүч, сургалт, хяналт, тайлагналын зохицуулалт, тэдгээрийн дагуу бэлтгэх байгаль орчин, нийгмийн арга хэрэгсэл зэргийг багтаасан Зээлдэгчийн зүгээс хэрэгжүүлэх шаардлагатай, эсвэл хэрэгжүүлэхэд хүрэх материаллаг арга хэмжээ болон үйл ажиллагааг тодорхойлсон нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
6. “Байгаль орчин, нийгмийн стандарт” буюу “БОНС” гэж Банкнаас хэвлүүлж, 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон (i) “Байгаль орчин, нийгмийн стандарт 1: байгаль орчин ба нийгмийн эрсдэл, нөлөөллийн үнэлгээ ба менежмент”; (ii) Байгаль орчин, нийгмийн стандарт 2: ажиллах хүч ба ажлын нөхцөл; (iii) Байгаль орчин, нийгмийн стандарт 3: нөөцийн үр ашиг ба бохирдлоос урьдчилан сэргийлэх, удирдах; (iv) Байгаль орчин ба нийгмийн стандарт 4: олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал; (v) Байгаль орчин, нийгмийн стандарт 5: газар чөлөөлөх, газар ашиглах болон албадан нүүлгэхийг хязгаарлах; (vi) Байгаль орчин, нийгмийн стандарт 6: биологийн олон янз байдлын хамгаалал ба амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент; (vii) Байгаль орчин, нийгмийн стандарт 7: уугуул иргэд/Африкийн сахар орчмын бүс нутгийн иргэд; (viii) Байгаль орчин, нийгмийн стандарт 8: соёлын өв; (ix) Байгаль орчин ба нийгмийн стандарт 9: санхүүгийн зуучлал; (x) Байгаль орчин, нийгмийн стандарт 10: “Талуудын оролцоо, мэдээллийн ил тод байдал”-ыг хамтад нь хэлнэ.
7. “Ерөнхий нөхцөл” гэж 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн (2023 оны 07 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн найруулсан) “ОУСБХБ-ны санхүүжилт болон хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтэд хамаарах Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны ерөнхий нөхцөл”-ийг хэлнэ.
8. “кВ” гэж цахилгааны хүчдэл хэмжих стандарт хэмжүүр болох киловольт буюу нэг мянган (1000) вольт болно.
9. “ЭХЯ” гэж Зээлдэгчийн Эрчим хүчний яам, эсвэл түүний хууль ёсны залгамжлагч этгээдийг хэлнэ.
10. “СЯ” гэж Зээлдэгчийн Сангийн яам, эсвэл түүний хууль ёсны залгамжлагч этгээдийг хэлнэ.
11. “Олон үе шатлалт хөтөлбөр” буюу “ОУШ Хөтөлбөр” товчлол гэж Ази, Номхон далайн бүс нутгийн цахилгаан, дулааны дэд салбарт сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар эрчим хүчний шилжилтийг түргэтгэхэд чиглэсэн олон шатлал бүхий хөтөлбөрийг хэлнэ.

24 11 сарын 13 2024

12. “Үйл ажиллагааны зардал” гэж тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламж, оффисын байрыг түрээслэх, эсвэл урсгал засвар, засвар үйлчилгээ хийх, түлш, оффисын хэрэгцээний зүйлс, нийтийн аж ахуйн үйлчилгээ, хэрэглээний зүйлс, харилцаа холбооны зардал (шуудан, утас, интернэтийн зардал орно), тээвэр, орчуулга, хэвлэх, олшруулах зардал, банкны шимтгэл, хураамж, хэвлэн нийтлэх, сурталчилгааны зардал, даатгал, Төсөлтэй холбоотой хурал, уулзалтын зардал, Төсөлтэй холбоотой томилолтын зардал, гэрээт туслах ажилтан болон Төсөлтэй шууд холбоотой, гэхдээ Зээлдэгчийн төрийн албаны цалин хөлс, урамшуулал, шан харамж, түүнтэй адилтгах төлбөрийг оруулаагүй захиргааны бусад зардал зэрэг Төслийн үйл ажиллагааны өдөр тутмын зохицуулалт, удирдлага, хяналтад шаардлагатай бараа бүтээгдэхүүн, зөвлөхийн бус үйлчилгээний үндэслэл бүхий зардлыг хэлнэ.
13. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлийн Хавсралтын 85-р зүйлийн зорилгын үүднээс 2023 оны 09 дүгээр сард баталсан “Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт авч буй Зээлдэгчдэд зориулсан Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журам”-ыг хэлнэ.
14. “Төсөл хэрэгжүүлэх орон нутаг” гэж Зээлдэгчийн Багануур-Чойрын цахилгаан дамжуулах шугам дайран өнгөрөх Төв, Дундговь, Говьсүмбэр аймаг, Улаанбаатар хот болон төслийн хэрэгжилтийн явцад Ассоциатитай тохиролцон сонгосон бусад орон нутгийг нийтэд нь хэлнэ.
15. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2.(b) хэсэгт заасны дагуу Зээлдэгчийн байгуулж ажиллуулах нэгжийг, эсвэл түүний хууль ёсны залгамжлагч этгээдийг хэлнэ.
16. “Төслийн үйл ажиллагааны гарын авлага” гэж Зээлдэгчийн ЭХЯ-аар дамжуулан баталж, төслийг хэрэгжүүлэх явцад шинэчлэх гарын авлагыг хэлэх ба энэ нь (a) төслийн бүтэц, зохион байгуулалт, өдөр тутмын үйл ажиллагаа; (b) зарцуулалт, санхүүгийн менежмент; (c) худалдан авах ажиллагаа; (d) байгаль орчин, нийгмийн нөлөөллийг зохицуулах арга хэмжээ; (e) хяналт, үнэлгээ, тайлагнал, мэдээлэл харилцаа; (f) шударга байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө; (g) олон улсын сайн туршлага болон Төслийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагын дагуу хувийн мэдээлэл цуглуулж боловсруулалт хийх; мөн (h) Төслийн хэрэгжилтэд шаардлагатай захиргаа, санхүү, техникийн болон зохион байгуулалтын бусад зохицуулалт, дэг журам. Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр уг гарын авлагад үе үе өөрчлөлт оруулж болох ба гарын авлагын хуваарьт уг нөхцөлийг тусгана.
17. “Төслийн удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2. (a) хэсэгт заасны дагуу Зээлдэгчийн байгуулж ажиллуулах хороог, эсвэл түүний хууль ёсны залгамжлагч этгээдийг хэлнэ.
18. “Гарын үсэг зурсан огноо” гэж Зээлдэгч болон Банк хооронд энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлэх бөгөөд уг тодорхойлолт нь энэхүү Хэлэлцээр болон Ерөнхий нөхцөлд дурдагдсан “Зээлийн Хэлэлцээрийн огноо”-ны бүх эшлэлд хамаарна.
19. “Сургалт” гэж Банкнаас баталсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн Төслийн хүрээнд зохион байгуулах сургалт, семинарт хамрагдахад шаардагдах бараа, үйлчилгээний үндэслэл бүхий зардлыг хэлэх бөгөөд үүнд сургалт, семинарын болон томилолтын зардал, сургагч багшийн үйлчилгээ авах, байр түрээслэх, материал бэлтгэх, олшруулах, хэрэгжүүлэхтэй шууд холбоотой бусад зардал орох ба харин зөвлөхийн цалин хөлс болон Зээлдэгчийн төрийн албаны цалин, урамшуулал, шан харамж, түүнтэй адилтгах төлбөрийг үүнд оруулахгүй.

